



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 1/579

Мөрөн сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Арбулаг сумын төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, айл өрхүүдийг төвлөрсөн дулаан хангамжийн сүлжээнд холбох, дулааны эрчим хүчээр хангах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээгээр гүйцэтгүүлэх нээлттэй сонгон шалгаруулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Ц.Бэхбаяр – (Хөвсгөл аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газрын Захиргаа удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүд:

Г.Базар (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)

Х.Цэнд-Аюуш- (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Б.Бат-Оргил- (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

Д.Сандагдорж– (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Б.Одончимэг– (Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

2. Дээрх арга хэмжээний хэрэгжилтийг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч (Ц.Бэхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Хуягбаатар)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ